



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№249 /458/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.18

Цаг үе, үйл явдал

Ж.БОЛДБААТАР: ӨНГӨРСӨН ХУГАЦААНД ЦӨӨНГҮЙ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-17	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.481	3.486
EUR	3.785	3.796
CNY	516	518
RUB	49.50	50.50
JPY	27.10	27.30
KRW	2.86	2.90

ЗУРХАЙ



2022.01.18 / ЛХАГВА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 26

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.35-17.30
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Мунхрахуй

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нийт анги, байгууллагуудын дарга, санхүү, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтнуудын дунд танхимаар болон цахим байдлаар сургалт зохион байгуулагдаж байна. Тус сургалтаар төсвийн төлөвлөлт, зарцуулалт, төрийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, галын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг сайжруулах сэдвийн хүрээнд илтгэлүүд хэлэлцүүлэх бөгөөд Сангийн яам, Үндэсний аудитын газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, ҮБХИС хамтран ажиллах юм.

Эл сургалтын нээлтийн үеэр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар нийт бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ "Миний бие одоогийн албан тушаалд томилогдоод гурав дахь жилдээ ажиллаж байна. Энэ хугацаанд та бүхэнтэй хамтраад байгууллагын төсөв санхүүгийн зарцуулалт,


төрийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, аливаа осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар цөөнгүй ажлыг хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрсэн.

Өнгөрсөн жилүүдэд салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэл хурдацтай хийгдэж Зэвсэгт хүчний хэтийн болон дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилт тодорхойлогдож, анги, байгууллагуудын штабын бэлэн байдлын түвшинд ахиц гарсан, улс орны стратегийн бүтээн байгуулалтад тэргүүн эгнээнд оролцох болсон зэрэг ахиц дэвшлүүд гарч, салбарын үйл ажиллагааг төр засаг, иргэд тодорхой түвшинд үнэлж байна. Хөндлөнгийн хяналт, шалгалтын үр дүнгээр ч энэ нь баталгаажиж байгааг та бүхэн мэдэж байгаа. Тухайлбал, батлан хамгаалах салбар Авлигатай тэмцэх газраас гаргадаг "Шударга байдлын үнэлгээ"-гээр бусад салбар, яамдыг тэргүүлсэн.

Гэвч төсөв, санхүүгийн хариуцлагатай холбоотой зөрчил, дутагдал гарсаар байна. Иймд

дараах үүрэг, чиглэлийг та бүхэнд өгч байна. Үүнд, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төсөв болон төрийн өмч хөрөнгийг захиран зарцуулж буй эсэхэд тавих дотоод хяналтыг дээшлүүлэх, эд хөрөнгийн тооллогыг чанартай, үр дүнтэй явуулж, данс бүртгэлтэй нэг бүрчлэн тулган баталгаажуулж, дутсан болон илүүдсэн хөрөнгийн асуудлыг дор бүр нь зохих шатны хурлаар хэлэлцэж шийдвэрлэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар учир дутагдалтай байна. Мөн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроох, дутуу мэдээлэх зэрэг зөрчил ч буурахгүй байна. Тиймээс эдгээр алдаа дутагдлаас засаж, аливаа эрсдэлийг тооцон, гарч болох зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагад анхааран соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна" хэмээлээ.

НОМЫН САНЧДЫН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



болон номын санчдын сонирхсон асуултад хариулсан юм.

Энэ үеэр бригадын генерал Г.Болор хэлсэн үгэндээ номын санчдын мэргэжил, мэргэшлийг дээшлүүлж, сургалт, мэдээллийг цаг алдалгүй хүргэн, сурган дадлагажуулж, номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээг чанаржуулснаар Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэл, оюун санаа, мэдлэг боловсролын түвшин дээшлэхэд онцгой ач холбогдолтой болохыг онцлоод эрдэм, мэдлэгийг түгээгч та бүхэн энд сурсан, мэдсэн зүйлсээ нэгтгэл,

анги, байгууллагадаа очоод бодитоор ажил хэрэг болгохыг уриаллаа.

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын номын санчдыг уг сургалтад хамруулснаар анги, байгууллагуудын номын сангийн үйл ажиллагаа улам сайжирч, бие бүрэлдэхүүнийг соён гэгээрүүлэхэд чиглэгдсэн ажил, албан тушаалынхаа үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэдээллийг авч, шинэ санаа, дэвшилтэд арга барилд суралцан ажлын идэвх, санаачилга өсөн нэмэгдэх ач холбогдолтой гэдгийг холбогдох албаны хүмүүс хэлж байсан юм.

Зэвсэгт хүчний 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нэгтгэл, анги, байгууллагуудын номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, цахим номын сангийн тухай мэдлэг олгох, ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын "Номын сангийн үйл ажиллагааны заавар"-ын хэрэгжилтийг хангахад

дэмжлэг үзүүлэх зорилгоор "Мэргэжил арга зүйн сургалт"-ыг зохион байгуулж байна.

Уг сургалтад ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор зочин илтгэгчээр уригдаж нийт бие бүрэлдэхүүнд "Ном уншихын ач тус" сэдвээр үнэтэй мэдээлэл, сургамж, зөвлөгөө өгсний зэрэгцээ сургалтын төгсгөлд хугацаат цэргийн алба хаагч



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 671,376,056

Эдгэрсэн

Нийт: 642,723,293

Нас барсан

Нийт: 6,730,581

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ҮҮРЭГТНИЙ ҮНЭМЛЭХ ГАРДУУЛАВ



Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабаас цэргийн насны залуучуудад Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хүсэл эрмэлзэл төрүүлэх, цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгууллаа.

Уг үйл ажиллагаанд Баянзүрх дүүргийн 8, 10, 12, 13, 23, 37 дугаар хорооны 80 гаруй цэргийн насны залуус оролцож цэргийн үүрэгтний үнэмлэхээ гардан авсан юм.

Энэ үеэр Баянзүрх дүүргийн ЗДТГ-ийн дарга И.Баттөгс хэлсэн үгэндээ “Энд хуран чуулсан хүүхэд, залуус та бүхэн эх орныхоо

эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, Батлан хамгаалах үйл хэрэгт хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэх насанд хүрчээ. Тиймээс та бүхнийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж цэргийн албаа нэр төртэй хаана гэдэгт итгэлтэй байна” хэмээн онцлов.

Үүний дараагаар ЦДБЭЧ-ын болон Баянзүрх дүүргийн Соёлын ордны уран бүтээлчид хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид, хүүхэд залуус, тэдний ар гэрийн төлөөлөлд зориулсан урлагийн хэсэгчилсэн тоглолтоо өргөн барьсан юм.



ӨВЛИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭНД 270 ГАРУЙ ТАМИРЧИН ОРОЛЦОЖ БАЙНА



Тэмцээнийг нээж ЗХЖШ-ын дарга, бригадын генерал С.Ганбямба хэлсэн үгийнхээ эхэнд идэр гурван есийн жавар тачигнасан өдрүүдэд цэргийн хүний ёсоор бэлтгэл сургуулилтаа тасралтгүй чамбайруулсанд нь бахархаж байна гээд “Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг олон улс, тив, дэлхийд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” гэж цуурайтуулах нэгэн үндэс нь цэргийн сургалт, бэлтгэлтэй салшгүй холбоотой. Энэхүү өвлийн спортын арга хэмжээ нь тухайн оныхоо Зэвсэгт хүчний аварга шалгаруулах цэрэгжлийн болон нийтийн биеийн тамир, спортын анхны тэмцээн болж явагддагаараа ихээхэн онцлогтой юм.

Цэрэгжлийн спорт бол цэргийн биеийн тамирын сургалт бэлтгэлийн үндсэн суурь нь бөгөөд цэргийн алба хаагчдыг цэргийн хэрэгт хамгийн дөт замаар, шууд утгаар нь сургах, бэлтгэх, нөлөөлөх гол арга зам нь болдог.

Түүний дотор өвлийн спортын төрлүүд нь цэргийн алба хаагчдыг цаг агаарын хүнд нөхцөлд дасан зохицож, цанатайгаар үүрэг гүйцэтгэх техник, ур чадварыг нэмэгдүүлж, түүнд шаардлагатай тэсвэр хатуужлыг

суулгаж, бэлэн байдлыг нь бодитоор шалгах олон талын ач холбогдолтой” гээд тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцуулж буй Зэвсэгт хүчний анги байгууллагын удирдлага, удирдан зохион байгуулж байгаа бүрэлдэхүүнд талархал илэрхийлж, амжилт хүслээ.

Үүний дараа тэмцээний ерөнхий шүүгч буюу ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ цэрэгжлийн спортын цол, зэргийн болзол биелүүлсэн тамирчдад спортын цол олгогдож буйг зарлаж, тэмдгийг ЗХЖШ-ын дарга, бригадын генерал С.Ганбямба гардуулж өгөв. Шагнагдсан тамирчдын дунд хугацаат цэргийн алба хаагчид цөөнгүй байсан бөгөөд энэ удаагийн тэмцээнд түрүүч, байлдагч нар шигшигдэн оролцож байгааг шүүгч нар онцлон тодотгож байсан юм.

Нээлтийн төгсгөлд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн бүрэлдэхүүнээс хэсэгчилсэн урлагийн үзүүлэх тоглолтыг тамирчдад өргөн барив. Тэмцээн энэ сарын 20-ны өдөр хүртэл үргэлжилнэ.

Ахмад Д.БОЛОР

Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, Цэрэг спортын цогцолбор олон төрөлтийн тэмцээн 1 дүгээр сарын 16-ны өдрөөс Зэвсэгт хүчний Хужирбулан дахь Сургалтын төвд эхэллээ. Тэмцээний нээлтийн ёслол 1 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж, ЗХЖШ-ын дарга, бригадын генерал С.Ганбямба, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа болон Монголын цанын холбооны Удирдах зөвлөлийн дарга н.Лхагвадорж,

БХЯ, ЗХЖШ-ын газрын дарга, төрлийн цэргийн командлагч болон удирдах бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч, тэмцээний шүүгчид оролцов.

Тэмцээнд Зэвсэгт хүчний 25 анги байгууллагын 270 орчим шилдэг цэргийн алба хаагч оролцож байгаа бөгөөд олон улсын хэмжээний мастер 7, их спортын мастер 19, цэрэгжлийн спортын мастер, дэд мастер 26, цэрэгжлийн спортын зэрэгтэй тамирчин 40 гаруй тамирчин байна.



Цахим шууданд

НОМТОЙ НӨХӨРЛӨӨ...



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги нь 2022-2023 оны сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийхээ оюуны хэрэгцээг хангах, мэдээ, мэдээлэл хүргэх, номыг бүтээлчээр унших арга зүйд дадалжуулах, номын сангийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх зорилгоор “Номтой нөхөрлөө” аяныг санаачлан олон талт ажил, арга хэмжээг өрнүүлж байна.

Аяны хүрээнд “Нэг хүн-Нэг ном” хандивыг өрнүүлж байгаа бөгөөд ангийн захирагч, удирдлагуудын зүгээс бие бүрэлдэхүүнийхээ оюуны хэрэгцээнд зориулан 100 орчим бүтээлийг хувийнхаа зүгээс бэлэглэлээ.

Цэргийн мэргэжлийн болон цэргийн түүх, дэлхийн түүх, шинжлэх ухаан, хууль, уран зохиол, танин мэдэхүй, гадаад хэл зэрэг бүх төрлийг багтаасан номын дээжээр инженерийн цэргийнхэн ийнхүү баяжигдав.

Хошууч Э.ХАШЦАХИУР

УРАН БҮТЭЭЛЭЭ ӨРГӨН БАРИЛАА



цэргийн харилцааг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын бүтээлч үйл ажиллагааг шуурхай сурвалжлан мэдээлэх, түгээх ажилд цаг ямагт хамтран ажиллаж ирсэн хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтнуудтай хийсэн энэхүү уулзалтад зориулан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамт олон хүндэтгэлийн тоглолтоо өргөн барилаа.

Тус уулзалтад зориулсан цэргийн чуулгын тоглолт шинэлэг, сүүлийн жилүүдэд бүтээн туурвисан шилдэг бүтээлүүдээс бүрдсэнээрээ ихээхэн онцлогтой байсан төдийгүй хүндэт зочид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчид талархал дүүрэн хүлээн авч халуун алга ташилтаар мялаасаар байсан юм.



Зэвсэгт хүчний штабын мэдээллийн Сэтгүүлчдийн монголын сэтгүүл, мэргэжлийн удирдлага, албанаас Нэгдсэн цахим холбоод, Жанжин мэдээллийн албан тушаалтнуудтай хийх уулзалтыг 3 дахь жилдээ уламжлал болгон энэ өдөр зохион байгууллаа. “Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэн-